



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/89

Хэрлэн сум

Газар эзэмших эрх хэсэгчлэн  
дуусгавар болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 49.3.1, Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3, 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газраас гаргасан хүсэлтийн дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын эзэмшиж байгаа Хэрлэн сумын 3 дугаар баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын зүүн хойд талд байрлах 2311031419 нэгж талбарын дугаартай 2884 м<sup>2</sup> газраас 103 м<sup>2</sup> газрын эзэмших эрхийг дуусгавар болгосугай.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын эзэмшиж буй газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, гэрээний биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зохиулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА